



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Онцгой байдлын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/45/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.gov.mn](#)
Алтай хот
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Утас: 99998431 Цахим хаяг: g.gundmaag@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677 Цахим хаяг: d.erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Цэрэнханд
Утас: 99086371 Цахим хаяг: d.tsurenkhandd@audit.gov.mn



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.01.25 № 01

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Онцгой байдлын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйцээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Онцгой байдлын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Онцгой байдлын газар нь орон нутагтаа гамшгаас хамгаалах команд штабын болон иж бүрэн дадлага сургуулилалтыг зохион байгуулсан байна.

Аудитын гол асуудал

Улсын төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 664,339.6 мянган төгрөгөөр өссөн нь төрийн албан хаагчдын цалин, хөлс нэмэгдсэнтэй, гамшгаас хамгаалах сургуулилалттай холбоотой байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 2 хөтөлбөр, 3 зорилт, 56 арга хэмжээ зэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 54 арга хэмжээг бүрэн, 2 арга хэмжээг 80.0 хувь буюу нийт дүнгээр 98.0 хувиар биелэлтийг хүргүүлсэн бөгөөд Онцгой байдлын ерөнхий газраас 92.0 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хэлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

• 07822005

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангиг эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэх болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах зөрөглөгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	701,968.3	784,784.7
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,608,140.3	5,344,052.9
Нийт хөрөнгийн дүн	6,310,108.6	6,128,837.6
Нийт өр төлбөрийн дүн		
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,310,108.6	6,128,837.6
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,310,108.6	6,128,837.6
Үйл ажиллагааны орлогын дүн	2,168,035.9	
		2,474,227.1
Үйл ажиллагааны зардлын дүн	1,991,458.4	
		2,655,498.1
Үйл ажиллагааны үр дүн	0.0	0.0
Үйл ажиллагааны бус үр дүн	0.0	0.0
Үйл ажиллагааны нийт үр дүн	1,991,458.4	2,655,498.1
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6,310,108.59	6,128,837.57
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,133,531.1	6,310,108.59
Тайлант оны үр дүн	176,577.4	(181,271.02)
Эцсийн үлдэгдэл	6,310,108.59	6,128,837.57
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,490,061.2	2,123,942.7
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,337,764.7	2,090,921.7
Үйл ажиллагааны ЦМГ	152,296.5	33,021.0
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(152,296.5)	(33,021.0)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.0	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,327,555.8	2,005,113.3
Урсгал зардал	1,175,259.3	1,972,092.3
Хөрөнгийн зардал	152,296.5	33,021.0
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,327,555.8	2,005,113.3
Улсын төсвөөс санхүүжих	1,327,555.8	2,005,113.3
Орон нутгийн төсвөөс санхүүжих		

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын илрүүлэлт

Аудитаар 37,748.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Хуультай холбоотой:** Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нөвтрэлтийн нэгдсэн системд бүртгээгүй 37,748.0 мянган төгрөгийн гүйлгээг системд нөхөн шивүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.7-т "Анхан шатны баримтын

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 17,652.9 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 17,652.9 мянган төгрөгийн 6 зөрчил² илэрснээс, 17,652.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх талаар 5 албан шаардлага, 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

Албан шаардлага

1. Биет тооллогоор 5,431.1 мянган төгрөгийн 6 аккумулятор дутагдсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тооллогоор дутагдсан хөрөнгө 5,431.1 мянган төгрөгийн хөрөнгийг тооцоо нийлж, биелэлтийг ирүүлэх албан шаардлага хүргүүлсэн.

2. Эдийн засгийн ангилал зөрчин бичиг хэрэг, урсгал засварын зардлаас 6,104.2 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй, ангилал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг ангиллын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлсэн.

3. Хяналт тавих эрх бүхий этгээдэд өөрт харьяалагдах доод албан тушаалын ажил хавсруулан 5,781.1 мянган төгрөгийн цалинг олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3-д "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг дараах журмаар түр орлон гүйцэтгүүлнэ. 43.3.3. энэ хуулийн 43.3.1, 43.3.2-т зааснаас бусад тохиолдолд албан тушаалтны албан үүргийг тухайн төрлийн албан тушаалын чиг үүрэгт нь хамгийн ойр хамааралтай албан хаагчтай тохиролцсоны дагуу түр орлон гүйцэтгүүлэх" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Ажил хавсран гүйцэтгүүлэхдээ хууль, дүрэм журмаа мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

4. Хүнсний зардалд 37,564.3 мянган төгрөг, барилгын засвар 50,400.7 мянган төгрөг, ланд 200-гийн засвар 21,314.4 мянган төгрөг зарцуулсан боловч худалдан авах ажиллагаа тендер зарлаагүй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах албан шаардлага хүргүүлсэн.

5. Эд хариуцагчийн ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийн (шатахууны талоньг) ахлах нягтлан бодогч давхар гүйцэтгэсэн байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна", 68 дугаар зүйлийн 68.1-т "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эсэмүдэл.

бүртгэн авч хадгалах, түүнийг нэр төрөл, чанар, бүрдлийн хувьд бүрэн бүтэн байлгах, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тавьж олгох, үүрэг бүхий нэгтгээдийг эд хариуцагч гэнэ", Ахлах нягтлан бодогч, Эд хариуцагчийн ажлын байрны тодорхойлолттой нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийн мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогч алын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Ур чадварын нэмэгдлийг шалгуурын дагуу дүгнээгүй, сар бүр хавтгайруулан 13,649.0 мянган төгрөгийг олгосон нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тушаал "төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам", Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, сангийн сайдын хамтарсан 1996 оны 24 сарын 20-ны өдрийн 63/104 дүгээр тушаал "Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох журам"-ын 5-д "ажилтанд олгож байгаа ур чадварын нэмэгдлийг заасан хязгаарт багтаан нэмэгдүүлэх, бууруулах асуудлыг улирал бүр хэлэлцэн шийдвэрлэж байна", 7-д "7.Ур чадварын нэмэгдлийг ажилтнуудын цалинг нэмэх, амьдрал ахуйг харгалзах зэргээр хавтгайруулан олгохыг хориглоно" тай нийцэхгүй байна. нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ур чадварыг нэмэгдлийг олгохдоо улирал бүр шалгуурын дагуу дүгнэж олгох

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/ сая төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
Онцгой байдлын газар	1	37.7	1	37.7			1	37.7				
Дүн	1	37.7	1	37.7			1	37.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		/ сая төгрөгөөр/			
									Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	Тоо	Дүн
									Албан тушаалтны тоо			

Онцгой байдлын газар	4	17.6	-	-	3	17.6	1				
Дүн	4	17.6	-	-	3	17.6	1				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуулал											
Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Төлбөр		
	/сая төгрөгөөр/										
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил											
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил											
Онцгой байдлын газар	2	0	-	-	-	0	-	-	-		
Дүн	2	0	-	-	-	0	-	-	-		
-Нийт дүн	2	0	-	-	-	0	-	-	-		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр	Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	
3	Түүвэрт хамруулсан		4	5	7					8
A	1	2	3	4	5	7	8	9	10	
1	ТШЗ		1			1				
	НИЙТ		1			1				